



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2021 оны 10 сарын 23-ны өдөр

Дугаар 2021/10-01

Улаанбаатар хот

Нэг талаас “Төгөлдөр урлаг” ТББ түүнийг төлөөлж менежер Б.Цолмон /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас Үндэсний Урлагийн Их театрыг төлөөлж нар /цаашид “Гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэх/ харилцан тохиролцож “Монгол улс НҮБ-д элссэний 60 жилийн хүндэтгэлийн хүлээн авалт”-д урлагийн тоглолтоор оролцох /цаашид ажил гэх/ гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь “Монгол улс НҮБ-д элссэний 60 жилийн хүндэтгэлийн хүлээн авалт”-д урлагийн тоглолтоор оролцох ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хийх, Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгч талд гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь дор дурдсан ажил үйлчилгээг үзүүлнэ.
 - 1.2.1 2021 оны 10 дугаар сар 24-ний 16:00 цагаас арга хэмжээний хяналтад оролцох.
 - 1.2.2 2021 оны 10 дугаар сар 25-ны өдрийн 16:00-21:00 цагийн хооронд урлагийн тоглолтоороо оролцох.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 2.1 Талууд харилцан тохиролцсоны дагуу Захиалагч нь доорх үнийн дагуу үйлчилгээг авна. Үүнд:

№	Тоглолтын хамрах хүрээ, нэр	Зохион байгуулах газар, хугацаа	Гэрээний үнэ /төгрөг/
2.1.1	“Монгол улс НҮБ-д элссэний 60 жилийн хүндэтгэлийн хүлээн авалт”-ын бэлтгэл хяналт, үндсэн үйл ажиллагаанд урлагийн тоглолтоор оролцох	Шангри-Ла зочид буудал Ball room 2021 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүд	10,000,000 төгрөг

- 2.1.2 Төлбөр болох 10,000,000 /Арван сая/ төгрөгийг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор банкны тоот дансанд төлнө.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Энэхүү гэрээ нь 2021 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 3.2 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсанаас хойш Гэрээний хугацаа дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Захиалагч дараах эрх эдлэнэ. Үүнд:
 - 4.1.1 Ажил үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;
 - 4.1.2 Ажлын явцад хяналт тавьж, ажлын чанарыг шалгах, ажил байдлын талаар санал дүгнэлтээ илэрхийлэх;
 - 4.1.3 Гэрээгээр заасан үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах.
- 4.2 Захиалагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1 Төлбөрийг гэрээнд заасан хугацаанд Гүйцэтгэгчид төлөх;
 - 4.2.2 Үйл ажиллагаан дээр хамтран ажиллаж буй тухайн хариуцсан удирдлага, ажилтнуудыг Гүйцэтгэгчтэй холбож өгөх;
 - 4.2.3 Бэлтгэл ажилд өөрчлөлт оруулах тохиолдолд Захиалагчид үйл ажиллагаа болох өдрөөс 1 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх;
 - 4.2.4 Гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангах, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дэмжин оролцох;
 - 4.2.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Гүйцэтгэгч нь дараах эрх эдлэнэ. Үүнд:
 - 5.1.1 Захиалагчаас гэрээнд заасан төлбөрийг нэхэмжлэн авах;
 - 5.1.2 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.
- 5.2 Гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 5.2.1 Гэрээний 1.2-д заасан ажил, үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэх;
 - 5.2.2 Үйл ажиллагааны бэлтгэл ажлын гүйцэтгэлийн өндөр чанарыг шаардаж ажиллах;
 - 5.2.3 Захиалагчийн саналыг харгалзан үзэж, хамтран ажиллах бүхий л таатай хэлбэрүүдийг хайж үр бүтээлтэй ажиллах;
 - 5.2.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Талууд нь Гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээг цуцалж, гэрээний төлбөрийг буцаан төлнө.
- 6.3 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, эсвэл дутуу биелүүлсэн тохиолдолд гэрээний нийт үнийн дүнгээс биелүүлээгүй ажлын үнийн дүнг хасах ба биелүүлээгүй ажлын үнийн дүнгийн 5%-тай тэнцэх хэмжээний торгуулийг Захиалагчид төлнө.
- 6.4 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувийн алданги тооцон Гүйцэтгэгчид төлнө.
- 6.5 Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу Захиалагчид үзүүлэх үйлчилгээг зөвхөн өөрөө биелүүлэх үүрэгтэй бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

Долоо. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйс

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлуулах, эсвэл ижил төрлийн үйл ажиллагааг Захиалагчийн хүсэлтээр гүйцэтгэж өгнө.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг Талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

Найм. Нууцлал

- 8.1 Талууд гэрээний нууцлалыг чанд сахиж, гэрээний нөхцөлийг гадагш задруулахгүй байх үүрэгтэй. Задруулсан тохиолдолд буруутай тал учирсан хохирлоо бүрэн хариуцна.
- 8.2 Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцан солилцсон мэдээлэл, баримтны нууцлалыг хугацаагүй хадгалах бөгөөд нөгөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардснаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.

Ес. Маргаан шийдвэрлэх

- 9.1 Гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд Зөвшилцөлд эс хүрвэл хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Бусад

- 10.1 Гэрээг Монгол хэл дээр бичгээр 2 хувь үйлдэн, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах ба талууд тус бүр 1 хувийг хадгалсан нь хууль, эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 10.2 Гэрээний нөхцөлд талууд харилцан тохиролцсоноор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд орох нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд хавсаргана.
- 10.3 Нэмэлт өөрчлөлт хавсралт нь гэрээний салшгүй нэг хэсэг байх бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Төгөлдөр Урлаг” төрийн бус
байгууллагын менежер Б.Цолмон

Гарын үсэг: *Б.Цолмон*
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 14-р хороо, 84-45
тоот
Утас: 99039048

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Үндэсний Урлагийн Их театрын
..... ажилтай

Гарын үсэг:
Хаяг:
Утас: